

## Яаралтай тусламжийн төв

Тус төв нь 240 эмч, сувилагч жолооч, инженер техникийн ажилтнууд өдөр шөнийн 24 цагийн турш биелүүлэн, хүн ардынхаа эрүүл мэндийн манааны тэргүүн шугам дээр зогсож байдгаараа бахархаж байдаг билээ.

Зорилго: Хүн амд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг дэлхийн өндөр хөгжилтэй орны төвшинд ойртуулж, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, нарийн мэргэжлийн эмчийн чадварлаг баг бүрдүүлсэн төв болох нь Яаралтай тусламжийн төвийн хэтийн зорилго мөн.

### Түүхэн үе шатууд

Яаралтай тусламжийн төв нь 1930 оны 10 дугаар сарын 20-нд Ардын Эрүүлийг хамгаалах Яамны сайдын тушаалаар Улсын клиникийн төв эмнэлгээс тусгаарлан гарч, 2 бага эмч, 3 асрагч, түргэн тусламжийн 1 морин тэрэгтэйгээр бие даасан үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд түүхэнд энэ өдрийг тус төвийн тулгын чулуу тавигдсан өдөр гэж үздэг.

1930-1950 он Түргэн тусламжийн үүсэл хөгжлийн эхлэл тавигдсан үе

1950-1970 Түргэн тусламжийн станцын материаллаг бааз өргөжиж, эмч мэргэжилтэн, жолооч, техникийн ажилчдаар бэхжиж хөгжсөн үе

1970-1980 Түргэн тусламжийн үйлчилгээнд нарийн мэргэжлийн тусламжийн бригадын үйлчилгээ нэвтэрсэн үе

1980-1990 он Эмнэлгийн яаралтай тусламж их эмчийн үйлчилгээнд бүрэн шилжсэн үе

1990-2000 он Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнтэй уялдуулан түргэн тусламжийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон шинэчилж орчин үеийн оношлог оо эмчилгээний багаж, хэрэгслээр хангагдаж эхэлсэн үе

2000-2007 он Эмнэлгийн үйлчилгээнд иж бүрэн тоноглогдсон зориулалтын машин, эмчилгээ, оношлог-ооны тоног төхөөрөмж, компьютер, мэдээлэл техник хэрэгслээр хангагдах эхлэл үе

2007 он Үйлчлүүлэгчид-дээ дээдэлсэн үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн үе /Нийслэлийн зарим дүүргүүдэд салбар байгуулагдан, парк шинэчлэлт хийгдэж, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгох шинэ техник технологийг нэвтрүүлж эхэлсэн. Яаралтай тусламжийн төв зохион байгуулалтын хувьд захиргаа-санхүү, аж ахуйн, хүн хүч, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн яаралтай тусламж үйлчилгээ, эмчилгээний чанарын хяналт, статистик- мэдээлэл, авто аж ахуйн хангамж, дуудлагын оператор, холбоо ашиглалтын албадтай ажилладаг

Нийслэлийн хэмжээнд яаралтай тусламжийн төвд хоногт 400-450 орчим жилдээ, 130,0-135,0 мянга орчим дуудлага иргэдээс хүлээн авч ажилладаг тусгай мэргэжлийн төв юм.

Яаралтай тусламжийн төвийн дарга нар : С.Дугарсүрэн, Г.Бат-чулуун, Ц.Бадам, Г.Цулбуур, Ц.Пүрэвдаш